МАЛ АЖ АХУЙН ЗОХИСТОЙ ДАДАЛ

ГАРЫН АВЛАГА

2026 он

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон
Дэлхийн банкнаас
хамтран хэрэгжүүлж буй Бэлчээрийн мал аж ахуйн
“Цахим хоршоо" төслөөс бэлтгэв.

Санхүүжүүлэгч: Японы нийгмийн хөгжлийн сан

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Эмхэтгэсэн:

Др В.Болормаа, Дэлхийн банкны “Цахим хоршоо” төслийн зөвлөх

Др Н.Ганхуяг, Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбооны
Гүйцэтгэх захирал

Редакторласан:

Др Ц.Мөнхнасан, ХХААХҮЯ-ны ахлах шинжээч

Government of Japan

JSDF
Japan Social Development Fund

THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP

МОНГОЛЫН
БЭЛЧЭЭР АШИГЛАГЧДЫН
НЭГДСЭН ХОЛБОО

Өмнөх үг
1. Оршил
2. Зохистой дадлын үндсэн зарчим
    2.1 Малын таван эрх чөлөө (ISO 22786:2025)
    2.2 “Хариуцлагатай нүүдэлчин” зохистой дадлын үндсэн зарчим (MNS 6891)
    2.3 SFA/THHЭ стандартын тулгуур зарчим
3. Бэлчээрийн зохистой ашиглалт
    3.1 Ерөнхий шаардлага
    3.2 Бэлчээрийн даац ба мониторинг
    3.3 Нүүдлийн зохицуулалт
    3.4 Бэлчээрийн нөхөн сэргээлт
    3.5 Малчдын хамтын ажиллагаа
4. Малын эрүүл мэнд ба тавлаг байдал
    4.1 Ерөнхий шаардлага
    4.2 Вакцинжуулалт ба дархлаажуулалт
    4.3 Биоаюулгүй байдал
    4.4 Эмийн хэрэглээ ба хяналт
    4.5 Малын тавлаг байдал
5. Тэжээл ба усан хангамж
    5.1 Ерөнхий шаардлага
    5.2 Тэжээлийн шаардлага
    5.3 Усан хангамжийн шаардлага
6. Малын үржүүлэг ба селекц
7. Түүхий эд бэлтгэл
    7.1 Ерөнхий шаардлага
    7.2 Ноос, ноолуур бэлтгэл
    7.3 Сүү бэлтгэл
    7.4 Мах бэлтгэл
    7.5 Арьс шир бэлтгэл

ӨМНӨХ ҮГ

Др Т.Жамбалцэрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Монгол Улсын мал аж ахуй нь олон зуун жилийн турш нүүдлийн соёл иргэншил, уламжлалт мэдлэг, байгальтайгаа зохицон амьдрах арга ухаанд тулгуурлан хөгжиж ирсэн бөгөөд өнөөдөр ч улс орны эдийн засаг, хүнсний аюулгүй байдал, хөдөөгийн иргэдийн амьжиргааны чухал тулгуур салбар хэвээр байна. Гэвч дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн доройтол, байгалийн нөөцийн хомсдол, олон улсын зах зээлийн чанар, тогтвортой үйлдвэрлэлд тавигдах шаардлага өсөн нэмэгдэж буй өнөө үед мал аж ахуйг хариуцлагатай, байгаль орчинд зөлтэй, тогтвортой хөгжүүлэх нь нэн чухал зорилт болоод байна.

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдөр батлсан Малчны тухай хуульд малчин нь байгалийн нөөц, бэлчээр, усны эх үүсвэрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, мал маллагааны уламжлалт болон шинжлэх ухаанд суурилсан арга барилыг хэрэгжүүлэх, малын эрүүл мэнд, генетик нөөцийг хамгаалах, мал, малын гаралтай бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах хүрээнд зохистой дадлыг хэрэгжүүлэхийг тодорхой тусгасан. Энэхүү эрх зүйн зохицуулалт нь мал аж ахуйн тогтвортой хөгжлийг хангах үндсэн суурийг бүрдүүлж байна.

Энэ хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Монгол Улсын бэлчээрийн мал аж ахуйн онцлог, уламжлалт арга ажиллагааг олон улсын тогтвортой үйлдвэрлэлийн зарчимтай уялдуулан MNS 6891 “Хариуцлагатай нүүдэлчин – Зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавих шаардлага” үндэсний стандартыг боловсруулж батлуулсан. Үүний зэрэгцээ Монгол Улсын санаачилгаар боловсруулсан ISO 22786 “Мал, амьтны тавлаг байдал – Ноолуур бэлтгэх, шошголох, үйлдвэрлэх, мөшгөх тогтолцоонд тавих шаардлага” олон улсын стандарт 2025 онд батлагдсан нь Монголын мал аж ахуйн салбарын нэр хүндийг олон улсын түвшинд ахиулсан чухал үйл явдал болсон юм. Мөн Тогтвортой ноос, ноолуурын эвсэл (SFA)-ээс хэрэгжүүлж буй тогтвортой үйлдвэрлэлийн стандартууд нь дэлхийн зах зээлийн шаардлагыг хангах, хариуцлагатай нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж байна.

Энэхүү гарын авлага нь дээрх хууль, үндэсний болон олон улсын стандартуудын шаардлагыг нэгтгэн, малчид, малчдын хоршоо, сум, багийн байгууллага болон салбарын бусад оролцогчдод зориулсан практик зөвлөмж, хэрэгжүүлэх аргачлалыг багтаасан болно. Зохистой дадлыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэвшүүлснээр малын тавлаг байдлыг хангах, бэлчээрийг тогтвортой ашиглах, байгаль орчныг хамгаалах, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, ул мөрийн мөшгөх тогтолцоог сайжруулахын зэрэгцээ малчдын өрхийн орлого, зах зээлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх боломж бүрдэх юм.

Монголын уламжлалт мал аж ахуйг орчин үеийн тогтвортой хөгжлийн зарчимтай хослуулан хөгжүүлэхэд энэхүү гарын авлага бодитой дэмжлэг үзүүлж, зохистой дадлыг төлөвшүүлэх, хариуцлагатай үйлдвэрлэлийг түгээн дэлгэрүүлэх, мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжил, олон улсын өрсөлдөх чадварыг бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна

ОРШИЛ

Мал аж ахуй нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн тулгуур салбар бөгөөд хүн амын хүнсний хангамж, үндэсний үйлдвэрлэл, экспортын орлого, малчин өрхийн амьжиргааны үндсэн эх үүсвэр болсоор ирсэн. Мөн уламжлалт нүүдлийн соёл, бэлчээрийн мал аж ахуйн онцлогийг хадгалан хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэвч сүүлийн жилүүдэд бэлчээрийн даац хэтрэх, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөө нэмэгдэх, малын эрүүл мэндийн эрсдэл өсөх, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, гарал үүслийн баталгаажуулалтын шаардлага өндөрсөх зэрэг олон талын сорилт энэ салбарын тогтвортой хөгжилд бодитой нөлөөлөх болсон.

Эдгээр сорилтыг даван туулах, мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашиг, тогтвортой байдлыг дээшлүүлэхэд зохистой дадлыг мал аж ахуйн үйлдвэрлэлд үе шаттайгаар нэвтрүүлж, хэвшүүлэх нь нэн чухал юм. Зохистой дадал нь малын таван эрх чөлөөг хангах, бэлчээрийг тогтвортой, хариуцлагатай ашиглах, малын эрүүл мэндийг хамгаалах, эм, биобэлдмэлийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах, ул мөрийн мөшгөх тогтолцоог хэрэгжүүлэх, түүнчлэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах зэрэг харилцан уялдаатай цогц арга хэмжээг хамардаг.

Зохистой дадлыг мал аж ахуйдаа хэрэгжүүлснээр бэлчээрийн даац хэтрэлтээс урьдчилан сэргийлж, бэлчээрийн ургамлын нөхөн сэргэх чадавхыг хадгалах, малын өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулан вакцинжуулалт, дархлаажуулалт болон мал эмнэлгийн эмийн зохистой хэрэглээг хэвшүүлэх боломж бүрдэнэ. Үүний зэрэгцээ ноос, ноолуур, сүү, мах, арьс, шир зэрэг малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг олон улсын стандарт, шаардлагад нийцүүлж, ул мөрийн мөшгөх тогтолцоогоор гарал үүсэл, үйлдвэрлэлийн мэдээллийг баталгаажуулах замаар хэрэглэгчийн итгэлцлийг нэмэгдүүлж, зах зээл дэх өрсөлдөх чадварыг бэхжүүлэх ач холбогдолтой.

ОРШИЛ

Түүнчлэн зохистой дадлыг хэрэгжүүлэх нь малын тав тух, сайн сайхан байдлыг хангахын зэрэгцээ байгаль орчны доройтлыг бууруулах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулна. Ингэснээр малчдын үйлдвэрлэлийн бүтээмж, орлогын тогтвортой өсөлтийг дэмжиж, Монгол Улсын мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжил, олон улсын зах зээл дэх Монголын малын гаралтай бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар, нэр хүндийг нэмэгдүүлэх чухал үндэс суурь бүрдэнэ.

Энэхүү гарын авлага нь мал аж ахуйн үйлдвэрлэлд зохистой дадлыг хэрэгжүүлэхэд чиглэсэн зөвлөмж, шаардлагыг нэгтгэн боловсруулсан бөгөөд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид, малчин өрх, хоршоо, аж ахуйн нэгж, боловсруулах үйлдвэр, мэргэжлийн байгууллага болон салбарын бусад оролцогчдод зориулсан болно.

Гарын авлагыг дараах үндэсний болон олон улсын стандарт, шаардлагад тулгуурлан боловсруулав. Үүнд:

- ISO 22786:2025 – Ноолуурын нийлүүлэлтийн сүлжээнд мал амьтны тавлаг байдлыг хангах олон улсын стандарт;
- MNS 6891:2025 – Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэх үндэсний стандарт;
- SFA/ТННЭ, Хувилбар 1.02 – Малын гаралтай ширхэгтийн стандарт.

Энэхүү гарын авлагын зорилго нь мал аж ахуйн үйлдвэрлэлд зохистой дадлыг төлөвшүүлж, тогтвортой хөгжлийг дэмжихэд оршино. Үүнд:

- ✓ малын таван эрх чөлөөг хангаж, малын эрүүл мэнд, тавлаг байдлыг сайжруулах;
- ✓ бэлчээрийн нөөцийг хариуцлагатай, тогтвортой ашиглах, хамгаалах;
- ✓ малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, гарал үүсэл, ул мөрийн мөшгөх тогтолцоог сайжруулах;
- ✓ малчдын үйлдвэрлэлийн үр ашиг, өрсөлдөх чадвар, орлогын тогтвортой өсөлтийг дэмжих;
- ✓ Монгол Улсын мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжил болон малын гаралтай бүтээгдэхүүний олон улсын зах зээл дэх нэр хүнд, үнэлэмжийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах.

2. ЗОХИСТОЙ ДАДЛЫН ҮНДСЭН ЗАРЧИМ

2.1 Мал амытны таван эрх чөлөө (ISO 22786:2025)

Эрх чөлөө	Хэрэгжүүлэх арга хэмжээ
Өлсгөлөн, цангалт, тэжээлийн дутагдлаас ангид байх	Тэжээл, усны зохистой хангамж
Халуун, хүйтэн, тав тухгүй орчноос ангид байх	Саравч, байр, орчны зохистой нөхцөл
Өвчин, гэмтлээс ангид байх	Малын эрүүл мэндийн хяналт, вакцинжуулалт
Байгалийн зан үйлийг илэрхийлэх эрх	Бэлчээрийн чөлөөт хөдөлгөөн, нүүдлийн зохицуулалт
Айдас, дарамт, стрессээс ангид байх	Малын арчилгаа, тээвэрлэлт, түүхий эд бэлтгэлийн үеийн аюулгүй ажиллагаа

Зөвлөмж:

Мал амытны таван эрх чөлөөг хангах нь зөвхөн малын тавлаг байдлыг хамгаалаад зогсохгүй, бүтээгдэхүүний чанар, зах зээлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлдэг.

2. ЗОХИСТОЙ ДАДЛЫН ҮНДСЭН ЗАРЧИМ

2.2 “Хариуцлагатай нүүдэлчин” зохистой дадлын үндсэн зарчим (MNS 6891:2025)

Хариуцлагатай нүүдэлчин (MNS 6891:2025) зохистой дадал нь Бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид, сум, баг, малчдын бүлэг, хоршоо, сургалт болон тохирлын үнэлгээний байгууллагуудад хамаарах Монгол Улсын үндэсний стандарт бөгөөд дараах үндсэн зарчимд тулгуурлана:

1) Уламжлалт нүүдлийн мал аж ахуйн арга ажиллагааг нийгэм, эдийн засаг, зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдуулж боловсронгуй болгох;

2) Зохистой дадлыг нэвтрүүлэхдээ мал аж ахуйн тогтвортой байдлыг хангах, малчид, боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчид, хэрэглэгчид зэрэг оролцогч талууд харилцан итгэлцэл, үнэн зөв мэдээлэлд тулгуурлах;

Жишээ дүрэм:

- ✓ Малын тоог бэлчээрийн даацад тохируулан жил бүрийн төлөвлөгөөнд тусгах (MNS 6891:2024, 8.1.3).
- ✓ Малын түүхий эд бэлтгэлд 16-аас доош насны хүүхэд ажиллуулахыг хориглоно (MNS 6891:2024, 7.2).

2. ЗОХИСТОЙ ДАДЛЫН ҮНДСЭН ЗАРЧИМ

2.3 SFA/ТННЭ стандартын тулгуур зарчим

SFA/ТННЭ (Sustainable Fibre Alliance) стандарт нь олон улсын зах зээлд хүлээн зөвшөөрөгдсөн сайн дурын стандарт бөгөөд дараах дөрвөн тулгуурт суурилдаг:

1) Малын тавлаг байдал – Ноос, ноолуур самнах, хяргах ажиллагааны үеэр малын тав тухыг алдагдуулахгүй байх.

2) Бэлчээрийн тогтвортой байдал – Нүүдлийн зохицуулалт, нөхөн сэргээлт, усны эх үүсвэрийн хамгаалалт.

3) Байгаль орчны хамгаалал – Ноос, ноолуур угаах, боловсруулах явцад байгальд ээлтэй технологи ашиглах.

4) Малчдын амьжиргаа – Хоршооны зохион байгуулалт, зах зээлийн итгэлцлийг нэмэгдүүлэх.

Жишээ дүрэм (SFA/ТННЭ):

- ✓ Ноос, ноолуур боловсруулах явцад APEO төрлийн химийн бодис хэрэглэхийг хориглоно.
- ✓ Малчдын түвшинд баталгаажуулалт хийхдээ хөндлөнгийн аудитын тогтолцоог ашиглана.

3. БЭЛЧЭЭРИЙН ЗОХИСТОЙ АШИГЛАЛТ

3.1 Ерөнхий шаардлага

- Бэлчээрийн зохистой ашиглалт нь малын таван эрх чөлөөг хангах, байгаль орчны доройтлоос сэргийлэх, малын ашиг шимийг тогтвортой байлгах үндсэн нөхцөл юм.
- ISO 22786:2025: Малын байгалийн зан үйлийг хангах, чөлөөтэй идээшлэх боломж олгох, усны эх үүсвэрийг хамгаалах.
- MNS 6891:2025: Бэлчээрийн зохион байгуулалт, гэрээний хэрэгжилт, мониторинг, нөхөн сэргээлт.
- SFA/ТННЭ стандарт: Бэлчээрийн тогтвортой байдал, нөхөн сэргээлт, усны эх үүсвэрийн хамгаалалт, олон улсын зах зээлийн итгэлцэл.

3.2 Бэлчээрийн даац ба мониторинг

- Жил бүр бэлчээрийн даацын үнэлгээ хийж, малын тоог тохируулна.
- Бэлчээрийн голлох ургамлын эзлэх хувь суурь түвшнээс бууруулахгүй байх (MNS 6891:2025, 8.2.1).
- Малын тоо бэлчээрийн даацыг хэтрүүлэхгүй байх, экосистемийн хэвийн хэмжээг баримтлах.
- SFA/ТННЭ стандартын дагуу бэлчээрийн мониторингийн мэдээллийг олон улсын зах зээлд ил тод тайлагнах.

3. БЭЛЧЭЭРИЙН ЗОХИСТОЙ АШИГЛАЛТ

Бэлчээрийн даацын жишиг тооцоо

Малын төрөл	Нэг га-д ногдох тоо	Жилд идээшлэх хоног
Хонь	2-3	300 хоног
Ямаа	2-2.5	300 хоног
Үхэр	0.3-0.5	300 хоног
Адуу	0.4-0.6	300 хоног
Тэмээ	0.2-0.3	300 хоног

Тайлбар: Бэлчээрийн даацын жишиг тооцоо нь албан стандартын норм биш, харин Монгол орны бэлчээрийн судалгаа, уламжлалт маллагааны туршлага дээр үндэслэсэн зөвлөмжийн жишээ юм.

3. БЭЛЧЭЭРИЙН ЗОХИСТОЙ АШИГЛАЛТ

3.3 Нүүдлийн зохицуулалт

- Малчин айлын нүүдэл нь малын тарга хүч, бэлчээрийн даац болон улирлын онцлогт (өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа) тохируулан орон гэр, малаа нүүлгэн шилжүүлэх уламжлалт үйл ажиллагаа юм.
- Малчин өрхийн жилийн дундаж нүүдлийн тоо дөрөв ба түүнээс дээш байх шаардлагатай (MNS 6891:2025, 8.2.5.2).
- Улирлын нүүдлийн хуваарийг сумын ИТХ-аар батлуулж, батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ.
- ISO 22786:2025-д нүүдлийн маршрутыг усны эх үүсвэр, бэлчээрийн ургамлын нөхөн сэргээлттэй уялдуулан төлөвлөхийг шаарддаг.
- SFA/ТННЭ стандарт-ын дагуу нүүдлийн маршрутыг GPS болон газрын зураг ашиглан тэмдэглэж, олон улсын зах зээлд тайлагнах боломжтой.

Зөвлөмж:

Нүүдлийн маршрутыг жил бүрийн төлөвлөгөөнд тусгах нь бэлчээрийн ашиглалтыг илүү хяналттай болгодог.

3. БЭЛЧЭЭРИЙН ЗОХИСТОЙ АШИГЛАЛТ

3.4 Бэлчээрийн нөхөн сэргээлт

- Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг хамтын хүчээр зохион байгуулах (MNS 5914:2008).
- Хөнөөлт мэрэгчидтэй тэмцэхдээ MNS 6866:2020 стандартыг мөрдөх.
- ISO 22786:2025-д бэлчээрийн нөхөн сэргээлтийг малын байгалийн зан үйлийг хангахтай уялдуулан хэрэгжүүлэхийг шаарддаг.
- SFA/ТННЭ стандарт-ын дагуу нөхөн сэргээлтийн үр дүнг олон улсын аудитын тайлангаар баталгаажуулна.

3.5 Малчдын хамтын ажиллагаа

- Малчид бүлэг, хоршооны зохион байгуулалтад хамрагдаж, бэлчээр ашиглах гэрээг хамтран байгуулна.
- Хэсэг, бүлгийн хурлын ирц 70 хувиас дээш байх (MNS 6891:2025, 8.3.1.1).
- ISO 22786:2025-д хоршооны зохион байгуулалтыг ул мөрийн мөшгөх тогтолцоотой уялдуулан хэрэгжүүлэхийг шаарддаг.
- SFA/ТННЭ стандарт-ын дагуу хоршоогоор дамжуулан түүхий эдийн бэлтгэл, хадгалалт, зах зээлд нийлүүлэлтийг зохион байгуулж, олон улсын зах зээлд итгэлцлийг бий болгоно.

Жишээ дүрэм:

- Хадлангийн талбайг усжуулах, хашаажуулах замаар тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх.
- Уст цэг, хөв цөөрөм байгуулах, усны эх үүсвэрийг хамгаалах.

Зөвлөмж:

Хоршооны дотоод дүрмийг бүх гишүүд баталж гарын үсэг зурсан байх нь хамтын ажиллагааны итгэлцлийг нэмэгдүүлдэг.

4. МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД БА ТАВЛАГ БАЙДАЛ

4.1 Ерөнхий шаардлага

Малын эрүүл мэндийг хамгаалах нь малын таван эрх чөлөөг хангах, бүтээгдэхүүний чанарыг баталгаажуулах, малчдын орлогын тогтвортой байдлыг нэмэгдүүлэх үндсэн нөхцөл юм.

- ISO 22786:2025: Малын эрүүл мэндийн төлөвлөгөө, вакцинжуулалт, дархлаажуулалт, биоаюулгүй байдал, эмийн хэрэглээний хяналтын шаардлагыг тодорхойлсон.
- MNS 6891:2025: Халдварт болон зоонозын өвчингүй статус, биоаюулгүй байдлын анхан шатны арга хэмжээ, эмийн хүлээх хугацааны шаардлагыг тусгасан.
- SFA/ТННЭ стандарт: Малын тавлаг байдлыг хангах, өвчингүй сүргийг баталгаажуулах, олон улсын аудитын тогтолцоогоор хяналт тавих шаардлагыг тусгасан.

4.2 Вакцинжуулалт ба дархлаажуулалт

- ISO 22786:2025-д малын эрүүл мэндийн төлөвлөгөөнд вакцинжуулалтыг заавал тусгахыг шаарддаг.
- MNS 6891:2025-д дархлаажуулалтын дараах "хүлээх хугацаа"-г мөрдөх шаардлагатай (туулга, эмчилгээний дараа малын гаралтай бүтээгдэхүүнийг хүнсэнд хэрэглэх хүртэлх хугацаа).
- SFA/ТННЭ стандарт-ын дагуу вакцинжуулалтын бүртгэлийг олон улсын аудитын тайлангаар баталгаажуулна.

Жишээ дүрэм:

- Вакцин хийсний дараа малын гаралтай бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхээс өмнө **хүлээх хугацааг** баримтлах.
- Дархлаажуулалтын бүртгэлийг малчдын бүлэг, хоршооны түвшинд хөтлөх.
- Мал сүрэгтээ өдөр тутмын хяналт тавьж, малд өвчний шинж тэмдэг илэрсэн тохиолдолд 12 цагийн дотор сумын мал эмнэлгийн байгууллагад мэдэгдэх.

4. МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД БА ТАВЛАГ БАЙДАЛ

Дархлаа бүрэн тогтох хүртэлх болон малын биеэс эмийн үлдэгдэл гадагшлах хүлээх хугацааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл:

Малын гоц халдварт өвчний эсрэг вакцин хэрэглэсэн тохиолдолд үйлдвэрлэгчийн заавар болон мал эмнэлгийн холбогдох журмын дагуу тогтоосон хүлээх хугацааг мөрдөнө. Зарим вакцины хувьд вакцин хийснээс хойш 28 хоног (1 сар) хүртэл хугацаанд малын гаралтай бүтээгдэхүүнийг хүнсэнд хэрэглэх, зах зээлд нийлүүлэхийг хязгаарлах шаардлага тавигдаж болно.

- Хүлээх хугацаа (хориг): Вакцин хийснээс хойш тогтоосон хүлээх хугацаанд малын гаралтай бүтээгдэхүүнийг худалдаалах болон хүнсэнд хэрэглэхгүй. Энэ хугацаанд вакцины нөлөөгөөр малын биед дархлааны хариу урвал бүрэн тогтож, холбогдох шаардлагууд хангагдана.
- Дархлаа тогтох хугацаа: Вакцин хийснээс хойш тухайн вакцины төрөл, малын нас, биеийн байдлаас хамааран хамгаалах дархлаа дунджаар 14–21 хоногийн дотор бүрэлддэг.
- Малын эмчийн хяналт: Вакцин хийлгэсний дараа малчин малынхаа эрүүл мэндэд тогтмол ажиглалт хийж, ямар нэгэн сөрөг урвал, хэвийн бус шинж тэмдэг илэрвэл мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид даруй мэдэгдэнэ.

4. МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД БА ТАВЛАГ БАЙДАЛ

4.3 Биоаюулгүй байдал

- ISO 22786:2025-д малын байр, бэлчээрийн бүсийг тусгаарлах, ариутгал, халдварын хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэхийг шаарддаг.
- MNS 6891:2025-д биоаюулгүй байдлын анхан шатны арга хэмжээг малчид өөрсдөө хэрэгжүүлэх шаардлагатай.
- SFA/ТННЭ стандарт-ын дагуу биоаюулгүй байдлын төлөвлөгөө нь олон улсын аудитын шалгуурт нийцсэн байх шаардлагатай.

4.4 Эмийн хэрэглээ ба хяналт

- ISO 22786:2025-д антибиотик болон өсөлт дэмжих зорилгоор гормон хэрэглэхийг хориглодог.
- MNS 6891:2025-д эмийн хэрэглээний бүртгэл хөтөлж, эмийн хүлээх хугацааг заавал мөрдөхийг шаарддаг.
- SFA/ТННЭ стандарт-ын дагуу эмийн хэрэглээг олон улсын аудитын тайлангаар баталгаажуулж, ил тод тайлагнана.

4.5 Малын тавлаг байдал

- ISO 22786:2025-д малын тав тухтай орчин, эрүүл мэнд, айдас, дарамтгүй нөхцөлийг хангахыг шаарддаг.
- MNS 6891:2025-д малын арчилгаа, маллагааны технологи нь малд айдас, дарамт учруулахгүй байх шаардлагатай.
- SFA/ТННЭ стандарт-ын дагуу малын тавлаг байдлыг баталгаажуулах зорилгоор хөндлөнгийн аудит хийж, олон улсын зах зээлд итгэлцлийг бий болгоно.

Зөвлөмж:

- Малын байрны ариутгал, халдваргүйтгэлийн арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх.
- Усны эх үүсвэрийг гаднын бохирдлоос хамгаалах.

Жишээ дүрэм:

- Малын тэжээлд антибиотик хэрэглэхийг хориглоно.
- Эмийн хэрэглээг малын эрүүл мэндийн бүртгэлд тэмдэглэж, хоршооны түвшинд хяналт тавих.

Зөвлөмж:

- ✓ Мал тээвэрлэхдээ зориулалтын тээврийн хэрэгсэл ашиглах.
- ✓ Малын арчилгаа, маллагаанд айдас, дарамт учруулах технологи, арга барилаас татгалзах.

4. МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД БА ТАВЛАГ БАЙДАЛ

ISO 22786:2025 стандартад малын хашаа, байртай холбоотой дараах шаардлагуудыг тусгасан байна:

Хашаа, байрыг барихдаа тухайн орон нутгийн боломжит, амьтанд ээлтэй материалыг ашиглана. Үүнд: мод, банз, сүрэл, өвс, чулуу, шахаж хатаасан баас зэрэг орно. Малын хэвтрийг хуурай буюцаар бэлтгэнэ.

- Хашаа, байрыг үер, ус тогтохоос сэргийлэхийн тулд газрын гадаргаас өндөрлөг газар барина.
- Хашаа, байранд цэвэр ундны усны эх үүсвэртэй байна.
- Хөхүүл ишгэнд зориулсан тусгай байртай байна.
- Хашаа, байрны хаалга нь агааржуулалт, салхилуулалт сайтай байж, малын хэвтрийг хуурай байлгах нөхцөлийг хангана.
- Хашаа, байрны урт нь өргөнөөс хамаарч, хамгийн багадаа 6–12 м байна.

5. ТЭЖЭЭЛ БА УСАН ХАНГАМЖ

5.1 Ерөнхий шаардлага

Малын тэжээл, усан хангамж нь малын таван эрх чөлөөний эхний хоёр эрх чөлөөг хангах үндсэн нөхцөл юм. Үүнд:

- Өлсгөлөн, цангалт, тэжээлийн дутагдлаас ангид байх.
- Дулаан, хүйтэн болон тав тухгүй орчноос ангид байх.

- ISO 22786:2025 – Тэжээлийн чанар, хадгалалт, тэжээлийн норм, усны чанарт тавигдах шаардлагыг нарийвчлан тодорхойлсон.
- MNS 6891:2025 – Өвс, нэмэлт тэжээлийн нөөц, давс, хужрын бүртгэл, усны эх үүсвэрийн хамгаалалтын шаардлагыг тусгасан.
- SFA/ТННЭ стандарт – Малын тэжээл, усан хангамжийн тогтвортой байдлыг олон улсын аудитын тогтолцоогоор баталгаажуулдаг.

Ямааны тэжээлийн талбай (ISO 22786:2025)

Төрөл	Нас гүйцсэн эр ямаа	Нас гүйцсэн эм ямаа	Өсвөр насны ямаа	Ишиг
Талбай/м2	2-4	1.5-2	0.8-0.9	0.5

5. ТЭЖЭЭЛ БА УСАН ХАНГАМЖ

5.2 Тэжээлийн шаардлага

- ISO 22786:2025-д малын тэжээлд антибиотик болон өсөлт дэмжих зориулалттай гормон агуулахыг хориглодог.
- MNS 6891:2025-д өвөлжилт, хаваржилтын үеийн зориулан малд өгөх өвс, нэмэлт тэжээлийн 90 хоногийн нөөцтэй байх шаардлагатай.
- SFA/ТННЭ стандарт-ын дагуу тэжээлийн чанар, гарал үүслийн бүртгэлийг хөтөлж, олон улсын зах зээлд ил тод тайлагнахыг шаарддаг.

Өвлийн улиралд малд шаардлагатай нэмэлт тэжээлийн хэмжээг хүснэгтээр жишээлэн үзүүлэв. Энэ нь албан стандартын норм биш бөгөөд малын физиологийн хэрэгцээ, Монголын уламжлалт маллагааны туршлага дээр тулгуурласан дундаж хэмжээг зөвлөмжийн түвшинд оруулсан болно.

Малын төрөл	Өдөрт өгөх өвс (кг)	Нэмэлт тэжээл (кг)	Давс, хужир (гр)
Хонь	2-3	0.5-1	10-15
Ямаа	2-3	0.5-1	10-15
Үхэр	8-10	2-3	30-40
Адуу	6-8	1-2	25-35
Тэмээ	10-12	2-4	40-50

4. МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД БА ТАВЛАГ БАЙДАЛ

5.3 Усан хангамжийн шаардлага

- ISO 22786:2025: Малын ундны ус нь цэвэр, шинэхэн, бохирдолгүй байх ёстой.
- MNS 6891:2025: Малчдын бүлэг нь чанарын шаардлага хангасан усан хангамжийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байх шаардлагатай. Усны чанарын үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэхийг шаарддаг.
- SFA/ТННЭ стандарт: Усны эх үүсвэрийн хамгаалалт, уст цэг, хөв цөөрөм байгуулах ажлыг олон улсын аудитын тайлангаар баталгаажуулсан байна.

Усны эх үүсвэрийн хамгаалалт:

- Уст цэг, худаг, хөв цөөрмийг тогтмол засварлаж, бохирдлоос хамгаалах.
- Усны эх үүсвэрийн ойролцоо хог хаягдал, химийн бодис хадгалахыг хориглох.
- Малын бөөгнөрөл ихтэй үед усны эх үүсвэрийг хашаажуулж, ээлжлэн ашиглах нөхцөлийг бүрдүүлэх.

Малын физиологийн хэрэгцээ, Монголын уламжлалт маллагааны туршлага, судалгааны дундаж тоон дээр үндэслэсэн малын өдөр тутмын усны хэрэгцээг зөвлөмж болгон дараах хүснэгтэд үзүүлэв.

Малын өдөр тутмын усны хэрэгцээ

Малын төрөл	Өдөрт хэрэглэх ус (литр)
Хонь	4-6
Ямаа	4-6
Үхэр	40-60
Адуу	20-30
Тэмээ	30-40

Зөвлөмж:
Усны эх үүсвэрийг GPS болон газрын зураг тэмдэглэж, жил бүрийн төлөвлөгөөнд тусгах.

- Уст цэг, хөв цөөрөм байгуулахад хоршооны хамтын хөрөнгө оруулалт хийх.
- Усны чанарын шинжилгээг жил бүр хийлгэж, тайланг хоршооны бүртгэлд хадгалах.

6. МАЛЫН ҮРЖҮҮЛЭГ БА СЕЛЕКЦ

Малын үржүүлэг, селекц нь малын ашиг шимийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, бэлчээрийн тогтвортой ашиглалтыг хангах үндсэн нөхцөл юм.

- MNS 6891:2025 – Малын тоо толгой, бүтэц, чанарыг бэлчээрийн даацтай уялдуулан төлөвлөж, селекцийн ажлыг хоршооны түвшинд зохион байгуулах шаардлагыг тусгасан.
- ISO 22786:2025 - Малын үржүүлгийг нас, биеийн хөгжилд тохируулан зохион байгуулах, хээлтүүлгийн зохистой харьцааг мөрдөх, төллөлт болон төл бойжуулалтын үеийн арчилгаа, маллагааны шаардлагыг хангах нөхцөлийг тусгасан.

Үржүүлгийн чиглэл:

- Үхэр: Сүү, махны чиглэл.
- Хонь: Ноос, мах, сүүний чиглэл.
- Ямаа: Ноолуурын нарийн, урт ширхэгтийн чиглэл.
- Адуу: Уналга, уралдааны чиглэл.
- Тэмээ: Ноос, мах, сүүний чиглэл.

Жишээ дүрэм:

MNS 6891:2025 - Малын үүлдэрлэг байдал, бүс нутаг байгаль экологийн нөхцөл, чадамж, төрийн бодлогод нийцсэн мэргэжлийн үйлчилгээ авдаг байна.

MNS 6891:2025 - Малдаа жил бүр тогтоосон хугацаанд ангилалт хийлгэж, шилэн сонголт, заазлалтыг тогтмол хийлгэдэг байна.

ISO 22786:2025 - Өсвөр эм малыг бэлгийн бойжилтод хүрэхээс өмнө эсвэл нас бие гүйцсэн эм малын дундаж жингийн дор хаяж 65 хувьд (ойролцоогоор 32 кг) хүрэхээс өмнө хээлтүүлэхийг хориглоно..

ISO 22786:2025 - Төллөхөөс өмнө эм малыг төллөлтийн байр, хэсэгт шилжүүлж, төллөх үеийн орчны нөхцөлийг хангана. Төллөлтийн байрны температурыг 6–8 °C-ийн түвшинд байлгана.

7. ТҮҮХИЙ ЭД БЭЛТГЭЛ

7.1 Ерөнхий шаардлага

- Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар нь малын эрүүл мэнд, тэжээл, арчилгаа, бэлчээрийн зохистой ашиглалттай шууд уялдаатай.
- Чанартай бүтээгдэхүүн нь зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, малчдын орлогын тогтвортой байдлыг хангах нөхцөл болдог.
  - ISO 22786:2025 – Ноолуурын бэлтгэл, ангилал, сав баглаа боодол, ул мөрийн мөшгөх тогтолцоонд тавигдах шаардлагыг нарийвчлан тодорхойлсон.
  - MNS 6891:2020 – Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний анхан шатны боловсруулалт, хадгалалт, тээвэрлэлтийн шаардлагыг тогтоосон.
  - SFA/ТННЭ стандарт – Ноолуурын чанар, гарал үүслийн баталгаажуулалт, олон улсын зах зээлд итгэлцлийг бий болгох ул мөрийн мөшгөх тогтолцоог шаарддаг.

7. ТҮҮХИЙ ЭД БЭЛТГЭЛ

7.2 Ноос, ноолуур бэлтгэл

- Ноос, ноолуурыг технологийн хугацаанд нь буюу ноолуур үс нь хөөрч, хөндийрсөн үед бэлтгэнэ.
- Ноос, ноолуур бэлтгэх ажлыг зориулалтын байр, талбайд явуулна. Бэлтгэлийн байр нь уужим, гэрэлтүүлэг сайтай, хэт халуун эсвэл хүйтэн биш, салхинаас хамгаалагдсан, цэвэр, тэгш гадаргуутай байх шаардлагатай.
- Ноос, ноолуур бэлтгэх ажиллагаа нь малын тавлаг байдлыг алдагдуулахгүй байх ёстой. Нэг ямааг самнах хугацаа 30 минутаас хэтрэхгүй байна (ISO 22786:2025).
- Ноос, ноолуур бэлтгэх хүний нөөц нь самнах, хяргах арга техникт сургагдсан, малын тавлаг байдлын талаар мэдлэг ойлголттой, малыг зөв барих, уях ур чадвартай, ноос, ноолуурын ангилан ялгалт болон чанарын шаардлагын талаар мэдлэгтэй байх шаардлагатай.
- Ноос, ноолуурын гарал үүслийг баталгаажуулж, хоршооны түвшинд бүртгэл хөтөлнө.
- Ноос, ноолуурын ширхэгийн нарийн, урт, жигд байдал, хогт хольц болон хялгасны агууламж нь чанарын гол үзүүлэлтүүд бөгөөд чанарын ангиллыг холбогдох стандартуудад тодорхой заасан байдаг.
    - MNS 6375: Түүхий эд бэлтгэл. Ямааны ноолуур. Техникийн шаардлага
    - MNS 0036: Түүхий эд бэлтгэл. Тэмээний ноос. Техникийн шаардлага
    - MNS 0033: Түүхий эд бэлтгэл. Хонины ноос. Техникийн шаардлага
    - MNS 6377: Түүхий эд бэлтгэл. Сарлагийн хөөвөр. Техникийн шаардлага
    - MNS 0070: Түүхий эд бэлтгэл. Хөөвөр. Техникийн шаардлага

Зөвлөмж:
Ноолуур самнахдаа стандартын шаардлага хангасан сам ашиглаж, хэт чанга татах, огцом зулгаахгүй, малын арьс, ширхэгтийн гадаргууг гэмтээхгүй байх.

7. ТҮҮХИЙ ЭД БЭЛТГЭЛ

7.3 Сүү бэлтгэл

Сүү, сүүн бүтээгдэхүүнийг дараах стандартын шаардлагад нийцүүлэн бэлтгэнэ. Үүнд:

- MNS 4228: Малын түүхий сүү. Техникийн шаардлага
- MNS 4229: Эсэг цагаан идээ. Техникийн шаардлага
- MNS 4230: Уурагт цагаан идээ. Техникийн шаардлага
- MNS 4528: Тослог цагаан идээ. Техникийн шаардлага
  - Малын сүүг ашиглахдаа бэлчээрийн даац, ургамлын хүрэлцээ, зуншлагын байдал, төлийн өсөлт, малын тарга хүчтэй уялдуулан саалийн хугацааг тогтоож, өдөрт саах давтамжийг тодорхойлно.
  - Саалийн сав, хувин, шүүлтүүр нь хүнсний зориулалтын материалаар хийгдсэн байх бөгөөд саахаас өмнө тогтмол угааж, ариутгана.
  - Саахаас өмнө малын хөхийг цэвэр усаар угааж, шаардлагатай тохиолдолд халдваргүйжүүлнэ. Саалийн мал эрүүл, тайван байх бөгөөд саах үед малтай зөөлөн харьцаж, хүч хэрэглэхийг хориглоно.
  - Сүүний гарал үүслийг бүртгэж, ул мөрийн мөшгөх тогтолцоонд хамруулна. Саальчид хамгаалалтын хувцас, бээлий, малгай, гутал өмсөж, саалийн үед гараа угаах, ариун цэврийн шаардлага хангах дадлыг хэвшүүлнэ.

7. ТҮҮХИЙ ЭД БЭЛТГЭЛ

7.4 Мах бэлтгэл

Малын махыг дараах стандартын шаардлагад нийцүүлэн бэлтгэнэ.

- MNS 1111 – Үхэр, өсвөр үхэр, адууны өрөөл мах, хонь, ямаа, хурганы гулууз мах. Техникийн ерөнхий шаардлага.
- MNS 2457 – Мах, махан бүтээгдэхүүн. Хонь, ямааны хэсэглэж ангилсан мах. Ерөнхий шаардлага.
  - ✓ Малыг нядлах (төхөөрөх) зорилгоор тээвэрлэхдээ зориулалтын тээврийн хэрэгсэл ашиглаж, тохиромжтой тоогоор тээвэрлэнэ. Малыг хэт олноор ачих, зориулалтын бус тээврийн хэрэгслээр тээвэрлэхийг хориглоно.
  - ✓ Тээвэрлэсэн малыг нядлахаас өмнө хангалттай хугацаанд амраж, ус, тэжээлээр хангана. Хол зайд тээвэрлэсэн малыг 48–72 цаг амраасны дараа нядалж, боловсруулна.
  - ✓ Малын махыг зах зээлд нийлүүлэхдээ вакцинжуулалт, эмийн хэрэглээний дараах хүлээх хугацааг чанд мөрдөнө.
  - ✓ Хүлээх хугацаа дуусаагүй малын махыг хүнсэнд хэрэглэх болон зах зээлд нийлүүлэхийг хориглоно.
  - ✓ Вакцинжуулалт, эмийн хэрэглээний бүртгэлийг хөтөлж, ул мөрийн мөшгөх тогтолцоонд хамруулна.
  - ✓ Хол зайд тээвэрлэсэн тохиолдолд малыг амраж, ус, тэжээлээр хангана.
  - ✓ Идшинд зориулан нядлах малыг хүмүүнлэг аргаар, айдас, стресс, дарамт учруулахгүйгээр нядална. Малд зовиур учруулах, тохиромжгүй аргаар амь таслахыг хориглоно.

7. ТҮҮХИЙ ЭД БЭЛТГЭЛ

7.5 Арьс шир бэлтгэл

- Арьс ширийг MNS 0060:2013 Түүхий эд бэлтгэл, Боловсруулаагүй арьс шир. Техникийн шаардлага стандартын шаардлагад нийцүүлэн бэлтгэнэ.
- Малыг төхөөрөхдөө стресс дарамтгүй хүмүүнлэг аргаар амийг таслан, стандартад заасан аргачлалын дагуу арьс, ширийг нь салгаж авна.
- Өвчихдөө эвэр, туурай, шийр, чих, уруул, чив, засаа, дэлэн, сүүл зэргийг арьсанд үлдээхгүй салгасан байна.
- Арьс ширийг өвчихдөө шар мах, өөх дагуулахгүй, урах, эсгэж, огтлохгүй, нүх гаргахгүйгээр гэмтэлгүй бэлтгэнэ.
- Арьс, ширийг өвчиж авмагц хоёр цагаас хэтрүүлэхгүй дэл, сүүл, эвэр туурай, чихний мөгөөс, халим, шар мах, арьсанд цус, наалдсан өвс хоийг цэвэрлэсан байна. Арьс ширнээс шар мах, өөхний үлдэгдлийг хянгар болон, зориулалтын хутга эсвэл зориулалтын машин ашиглан цэвэрлэж, MNS 5094:2001 Чанарын хамгаалалт хийх, баглах, тээвэрлэх, хадгалах стандартын дагуу чанарын хамгаалалт хийсэн байна.
- Арьс ширэнд чанарын хамгаалалт хийх, баглах, хадгалах үйл ажиллагааг стандартын шаардлага хангасан зориулалтын байранд явуулах ба зориулалтын тэврийн хэрэгслээр тээвэрлэнэ

Маргаашийн Монголыг илүү тогтвортой, илүү хариуцлагатай, илүү үнэ цэнтэй болгохын төлөө бүгдээрээ хамтдаа алхъя.